

  
**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2022 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 9/36

Мандалговь

“Эрдэнэдалай сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”  
зөвлөхийн үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон  
шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Эрдэнэдалай сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” зөвлөхийн үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Ж.Түмэндэлгэр (Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны ахлах мэргэжилтэн)

Гишүүд:

Н.Мэндсайхан (Иргэний төлөөлөл)  
Ц.Лхагвасүрэн (Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

Б.Сэргэмядаг Аймгийн засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичиг:

Ж.Гантулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Түмэндэлгэр)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ



4822150080